



ТАВАН БОГД ПРОПЕРТИ ХХК
Хамтын хүч - Амжилтын түлхүүр



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 18-
Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ
ХЭРЭГЖИЖБУЙ “ТАВАН БОГД
ПРОПЕРТИ” ХХК-ИЙН “880 АЙЛЫН
ОРОН СУУЦ БОЛОНҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨВ БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН**

**2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН
ДУГААР: 6541216**

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 18-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ТАВАН БОГД ПРОПЕРТИ” ХХК-ИЙН “880 АЙЛЫН ОРОН СУУЦ
БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

ХЯНАСАН.

НБОГ-ЫН ХБОНБХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ж.БАТЗОЛБОО

БОЛОВСРУУЛСАН.

“ТАВАН БОГД ПРОПЕРТИ” ХХК-ИЙН
ХӨДӨЛМӨР АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

С.ЛУВСАНДАГВА

2023 он

АГУУЛГА

1.	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	1
1.1.	Төслийн байршил, товч танилцуулга	1
1.2.	Төслийн хүчин чадал	2
2.	ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	3
2.1.	Физик газарзүйн нөхцөл.....	3
2.2.	Уур амьсгал.....	4
2.3.	Агаарын чанар	4
2.4.	Физик бохирдол.....	5
2.5.	Геологийн тогтоц, геоморфологи	5
2.6.	Гадаргын ус	5
2.7.	Газрын доорх ус	6
2.8.	Хөрсөн бүрхэвч	6
2.9.	Ургамлан нөмрөг.....	6
2.10.	Амьтны аймаг.....	6
2.11.	Тусгай хамгаалалттай газар нутаг	7
2.12.	Түүх соёлын өв.....	7
2.13.	Нийгэм-эдийн засаг.....	7
3.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	9
3.1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	9
3.2.	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....	11
3.3.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	11
3.4.	Тэрбум модны хүрээнд хийгдэх ажлын биелэлт	12
3.5.	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	12
3.6.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	16
3.7.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт.....	17
4.	ХЭРЭГЖИЛТИЙН ЗУРГУУД.....	18


1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн байршил, товч танилцуулга

Төслийн нэр:	880 айлын орон сууц болон үйлчилгээний төв байгуулах
Төсөл хэрэгжүүлэгч:	“Таван Богд Проперти” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011815962
Регистрийн дугаар:	6541216
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Хан-Уул дүүрэг, 18-р хороо, Фидес Тауэр, 4 давхар, 401 тоот
Төсөл хэрэгжиж буй газрын байршил:	Хан-Уул дүүрэг, 18-р хороо, Нийслэл хүрээ гудамж

“Таван Богд Тайер” ХХК нь Нийслэлийн Засаг даргын захирамжын 2018 оны 12 сарын 07 өдрийн А/1176 тоот шийдвэрийг үндэслэн нэгж талбарын 1780610331 дугаар бүхий 29977 м.кв газрыг “Орон сууц, үйлчилгээ” зориулалтаар эзэмшдэг.

Тус газарт “Таван Богд Тайер” ХХК-аас гаргасан албан бичиг бүхий зөвшөөрлийг үндэслэн “Таван Богд Проперти” ХХК нь “880 айлын орон сууц болон үйлчилгээний төв байгуулах” төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



Зураг 1. Төслийн байршил


“Таван Богд Проперти” ХХК-ийн хэрэгжүүлж буй “880 айлын орон сууц болон үйлчилгээний төв байгуулах” төслийн талбай нь Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт байрлах ба хотын төвөөс зүүн урд зүгт Маршалын гүүр явах замд “International School of Ulaanbaatar” дунд сургуулийн баруун талд 29977 м.кв талбайд хэрэгжиж байна.

“Таван Богд Проперти” ХХК-ийн “880 айлын орон сууц болон үйлчилгээний төв байгуулах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Тус барилгын ажилд 60-80 хүн ажиллах ба нийт барилга угсралтын үргэлжлэх хугацаа 5 жил үүнээс эхний жилд талбай бэлтгэл, газар шорооны ажил, гадна шугам сүлжээний холболт хийгдэх бол барилга угсралт, гадна талбайн тохижилт 4 жил үргэлжилнэ гэсэн тооцоотой байна. Барилга нь 2022 оны 4-р улиралд эхний ээлжийг ашиглалтанд оруулахаар төлөвлөж байна.

1.2. Төслийн хүчин чадал

“Таван Богд Проперти” ХХК-ийн Төсөл нь тус бүрдээ 110 айлтай 23 давхар 8 блок барилга /зоорьтой/, 2 давхар 150 хүүхдийн цэцэрлэг, 2 давхар амралт зугаалгын хүрээлэн, 2 давхар худалдаа үйлчилгээний талбай, олон нийтийн ногоон байгууламжийн талбай, авто машины зогсоол зэргийг төлөвлөсөн бөгөөд хороолол дотор (онцгой тохиолдлоос бусад үед) авто машины хөдөлгөөнгүй аюулгүй орчинг төлөвлөхийг зорьсонтой холбогдуулан тусгай хэрэгцээт иргэд болон галын машин зорчих паднусыг холбогдох барилгын норм ба дүрэмд үндэслэн зураг төсөл, тооцоог боловсруулах төлөвлөсөн. Мөн барилгын өвөрмөц хэлбэртэй уялдуулан (6 талт) “Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх БНБД 31-01- 01” тусгагдсан заалтын дагуу өрөө тасалгааны талбай болон таазны өндөр, гэрэлтүүлэг, үүрэг, зориулалтыг төлөвлөхөөс гадна галын аюулаас хамгаалах нормыг баримтлан төлөвлөсөн. Мөн гадна тохижилтонд онцгой анхаарсан бөгөөд талбайд 1-3 насны хүүхдийн тоглоомын талбай, 3-7 насны хүүхдийн тоглоомын талбай, 7-12 насны хүүхдийн талбай, спорт талбай /сагсан бөмбөгийн болон газрын теннис/, олон нийтийн үйлчилгээний төв, 235 авто машины ил зогсоол, амралт зугаалгын хүрээлэн, өвлийн цэцэрлэг зэргийг төлөвлөсөн. 880 айлын орон сууцны хотхон нь барилгын өвөрмөц хэлбэртэй уялдуулан (6 талт) “Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх БНБД 31-01-01” тусгагдсан заалтын дагуу өрөө тасалгааны талбай болон таазны өндөр, гэрэлтүүлэг, үүрэг, зориулалтыг төлөвлөхөөс гадна галын аюулаас хамгаалах нормыг баримтлан төлөвлөсөн.



Зураг 2. Төслийн төлөвлөлтийн зураг



Зураг 3. Төслийн харагдах байдал

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Физик газарзүйн нөхцөл

“Таван Богд Проперти” ХХК-ийн Төслийн талбай Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт байрлана. Улаанбаатар хот нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай Хэнтийн уулархаг их мужийн баруун өмнөд шувтрагын хэсэгт Туул голын өргөн хөндийд байрлана. Хот өмнөд хэсгээрээ далайн түвшнээс дээш 2256 м хүртэл өндөр

“Таван Богд Проперти” ХХК-ийн “880 айлын орон сууц болон үйлчилгээний төв байгуулах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

өргөгдсөн Богд уулаар хүрээлэгдэнэ. Уулын ар хажуу нь зэрэгцээ байрлалтай олон жижиг ам хөндийгөөр хэрчигдсэн байдалтай эгц хажуутай, 600-900 метр харьцангуй өндөртэй байхад өвөр хажуу нь мөлгөржсөн хадан харш, илрэл элбэгтэй урт хөндийнүүдээр хэрчигдсэн байдаг.

Барилга баригдах талбай нь Туул, Сэлбэ голуудын хөндийд, голын усны зөөврөлөх үйл ажиллагаагаар үүссэн зөөгдөл-хуримтлалын тэгшивтэр гадаргуутай талбайд байрлана. Талбайд физик-геологийн үзэгдэл үйл явц хөгжөөгүй, талбайн гадаргуугийн өндөр 1288.81290 м хооронд хэлбэлзэнэ. Гадаргууд хүний инженерийн үйл ажиллагаагаар үүссэн асгамал хөрс янз бүрийн зузаантай тохиолдоно. Төслийн талбайн эргэн тойрон орон сууц, барилга байгууламж, нийтийн эзэмшлийн зам талбайгаар хүрээлэгдсэн бөгөөд хүн ам суурьшаад олон жил болсон, барилга байгууламж, үйлдвэрлэл, зам харилцаа эрчимтэй хөгжсөн учраас газрын гадаргын унаган төрх байдал бүрэн өөрчлөгдсөн Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт байрлана. Талбайд ус нөөцлөх сав, контейнэр 1ш, төмөр хашааны хаягдал, барилгын зарим материал, харуулын байр, ажилчдын гэр сууц зэрэг байна.

2.2. Уур амьсгал

Судалгааны талбай Монгол орны Барилгын төлөвлөлтөнд зориулсан уур амьсгалын мужлалтаар хүйтэн өвөлтэй, цасны ачаалал харьцангуй их, халуун хуурай зунтай бүсэд оршино. Цаг уурын үзүүлэлтийг Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт, БНБД 23-01-09–өөс Улаанбаатар хотын МУИС-ийн цаг уурын ажиглалтын станцын олон жилийн судалгааны материалын дундаж үзүүлэлтээр доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. МУИС-ийн цаг уурын ажиглалтын станцын үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоон утга
1.	Агаарын жилийн дундаж	°C	-0.5
2.	Агаарын үнэмлэхүй хамгийн их температур		33.8
3.	Үнэмлэхүй ихийн VII сарын дундаж		31.6
4.	Агаарын үнэмлэхүй хамгийн бага температур		-36.0
5.	I сарын үнэмлэхүй бага дундаж температур		-31.9
6.	Барилга, байгууламж, техник технологийн гадна агаарын тооцооны температур	Хамгийн хүйтэн үеийн	1 өдөр
			3 өдөр
			5 өдөр
			Агаар сэлгэлтийн
	Хамгийн халуун үеийн 1 хоногийн		26.4
7.	Агаарын чийгшил, хур тунадасны хэмжээ	Хоногийн хамгийн дулаан цагийн харьцангуй чийгшил	Халуун сар
			Хүйтэн сар
		Хур тунадас	Жил
			Дулаан үе
	Хоногийн хамгийн их	%	52
		мм	71
			271.2
			255.8
			53.8
8.	Салхины хурд	Жилийн дундаж	м/с
		20 жилд 1 удаа тохиолдох тооцооны хамгийн их хурд	1.3
9.	Салхины даралт qmax	5 жилд 1 удаа	gH/m ²
		10 жилд 1 удаа	
		20 жилд 1 удаа	
10.	Цасан бүрхүүлийн нормчилсон ачаалал	Кг/м ² (гПа)	50 /0.5/

2.3. Агаарын чанар

“Таван Богд Проперти” ХХК-ийн 880 айлын орон сууц болон үйлчилгээний төв байгуулах талбайд ямар нэг объект баригдаагүй. Барилга угсралтын ажлын үед бараа

материал тээвэрлэдэг автомашины яндангаас гарах утаа болон тоосжилт үүсч агаарын чанарт нөлөөлж болзошгүй. Төслийн үйл ажиллагаанаас одоогоор агаарын бохирдолд үзүүлэх нөлөө байхгүй. Нийслэлийн агаарт голлон тархсан бохирдуулагчид нүүрстөрөгчийн дутуу исэл, азотын давхар исэл, хүхэрлэг хий, том болон жижиг ширхэглэгт тоос, тоосонцор байдаг.

2.4. Физик бохирдол

Төслийн талбайд одоогоор ямар нэг үйл ажиллагаа эхлээгүй учир физик бохирдол үүсгэх эх үүсвэр байхгүй. Барилга угсралтын ажлын үед бараа материал тээвэрлэдэг автомашины яндангаас гарах утаа болон тоосжилт, мөн барилгын ажлын явцад тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээний нөлөөлөл үүсч болзошгүй. Талбайн хашаан дотор цаас, гялгар уут, хуванцар сав, цаасан хайрцаг зэрэг ахуйн хэрэглээний хог хаягдал хуримтлагдсан байгаа тул цаашид Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйл болон 10 дугаар зүйлд заасан журмыг баримтлах шаардлагатай.

2.5. Геологийн тогтоц, геоморфологи

Шинээр барихаар төлөвлөж буй барилгын талбайн геологийн тогтоцыг доод-дээд Карбон (C1-2)-ын настай ногоон саарал, хөх саарал өнгийн конгломерат, элсэн чулууны зузаалаг бүрдүүлэх бөгөөд дээд-орчин үеийн дөрөвдөгчийн настай аллюви (aQ3-4)-ийн болон аллюви-пролюви (aQ3-4)-ийн гаралтай элстэй Хайрга ба тоосорхог шаварлаг хайрган хөрсөөр хучигдсан байна.

Хөрсийг хөрс ангиллын нэгдсэн систем, ASTM D2487 стандартын дагуу нэрлэж ангилсан. Цооногуудад илэрсэн хөрс, чулуулгийг дараах байдлаар нэрлэж ангилсан. Үүнд:

- ✚ Орчин үеийн Дөрөвдөгчийн настай техноген гаралтай үүсмэл /асгамал/ хөрс
- ✚ Дээд-орчин үеийн Дөрөвдөгчийн настай аллюви (aQ3-4) болон аллюви-пролювийн (aQ3-4) гаралтай элс, тоос, шавар янз бүрийн хэмжээгээр агуулсан хайрган хөрс
- ✚ Доод-дээд Карбоны настай, тунамал гаралтай элсэн чулуу, конгломерат

2.6. Гадаргын ус

Улаанбаатар хот орчмын гол горхи, сайрууд нь бүхэлдээ Туул голын савд багтаж ус зүйн нөхцлийн сүлжээгээрээ Умард мөсөн далайн ай савд хамаарна. Гадаргын усны сүлжээний хувьд Сэлбэ, Туул гол урсан өнгөрөх ба олон тооны жижиг цутгалангуудтай. Тус төсөл хэрэгжих талбай нь Туул голоос 1 км зайтай байна.

Туул гол нь Хан Хэнтийн нурууны салбар уулс болох далайн түвшинээс дээш 2000 м өндөрт өргөгдсөн Чисаалайн сарьдаг, Шороотын давааны өврөөс гарах Намьяа, түвшинээс дээш 2000 м өндөрт өргөгдсөн Чисаалайн сарьдаг, Шороотын давааны өврөөс гарах Намьяа, Нэргүй хэмээх хоёр голын уулзвараас эх авч урсан Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт Орхон голд цутгадаг. Орхон гол нь Сэлэнгэ мөрөнтэй нийлж, улмаар ОХУ-ын нутаг дэвсгэрт Байгаль нуурт цутгана. Сэлбэ гол нь Хэнтийн нурууны урд хэсгийн салбар уулсад багтах бөгөөд далайн түвшинээс дээш 1510-1620 метр өндөрт оршдог. Нийт 342.2 км кв нутаг хамардаг. Энэ голын сав газарт ургамлын аймгийн 7 зүйл мод сөөг, 40 овогийн 183 зүйл ургамалтай.

2.7. Газрын доорх ус

Улаанбаатар хотын унд ахуйн усны хэрэглээг Туул голын хөндийн аллювийн хурдсын газрын доорх цэнгэг усны ордоос хангадаг. Хотын хүн амын нягтшил болон үйлдвэр аж ахуйн газрууд олноор нэмэгдсэнээр усны хэрэглээ ихсэж хот орчмын газрын доорх усны нөөц хомсдох, бохирдох нөхцөл үүсээд байгаа бөгөөд Туул голын сав газар ерөнхийдөө хүний үйл ажиллагааны нөлөөлөлд гүнзгий өртөж, голын усны горим алдагдаж экосистемийн доройтолд орж, хот суурин газрын агаар, хөрсөн бүрхэвч, бэлчээр доройтож, ойн болон дагалт баялгийн нөөц тодорхой хэмжээгээр хомсдолд орж байна. Улаанбаатар хотын хэмжээнд дөрөвдөгчийн сэвсгэр хурдсанд агуулагдсан дөрвөн уст горизонт, үндсэн чулуулгийн ан цав, нүх сүв, гүний хагарлуудын дагуух суларлын бүстэй холбоотой агуулагдсан дөрвөн уст комплекс бий. Орчин үеийн дөрөвдөгчийн аллюви, пролювийн уст горизонт (QIV): Талбайн хэмжээнд хамгийн томд орох Туул голын хөндий түүнд салбарлаж нийлдэг Толгойт, Сэлбэ, Улиастай голуудын цутгалын хэсэг хамаарагдана. Грунт ус нь зуны улиралд газрын гадаргуугаас 0.5-4.0 метрийн гүнд 1245-1320 метрийн үнэмлэхүй өндөрт харгалзах түвшинд илэрдэг.

Талбайн судалгаанд зориулан өрөмдсөн цооногуудад хөрсний ус 3.40-4.60 м-т илэрч, 3.24.4 м гүнд тогтсон байна. Хөрсний ус Туул, Сэлбэ голуудын устай гидравлик холбоотой оршдог ба голын ус болон гадаргын хур тунадасны усаар тэжээгдэнэ. Тэжээгдлээсээ хамааран одоогийн тогтсон түвшинээсээ 0.5 м-ээр түр дээшилнэ. Хөрсний ус илэрсэн цооногуудаас авсан усны дээж нь гидрокарбонат-сульфатын ангийн натри-кальцийн бүлгийн, I төрлийн найрлагатай, саармаг орчинтой, цэнгэг, зөөлөн ус бөгөөд “MNS AASHTO T 26:2005 Бетонд хэрэглэх усны чанарыг тодорхойлох арга” стандартын шаардлагыг хангаж байгаа болно.

2.8. Хөрсөн бүрхэвч

Төсөл нь Туул, Сэлбэ голуудын хөндийд, харьцангуй тэгшивтэр гадаргуутай талбайд хэрэгжих бөгөөд 6 төрлийн хөрс, чулуулгийн үе давхарга тархсан, хөрсний ус гадаргууд ойр оршдог, Туул болон Сэлбийн тектоник хагарлын бүсүүдийн уулзварт байрладаг, гүний чулуулгууд маш ихээр бутралд орж ан цавшсан, талбайн гадаргуугийн хэсэг хүний инженерийн үйл ажиллагаанд өртөж, асгамал хөрс 1.8-5.6 м зузаантай тархсан зэргээс инженер-геологийн дунд зэрэг төвөгтэй нөхцөлтэй ажээ.

2.9. Ургамлан нөмрөг

Байгалийн унаган төрхөөрөө байхдаа Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Хэнтийн уулын тайгын тойргийн хэв шинжид багтах алаг өвс-бутлаг үетэн, бутлаг алаг өвст хээрийн, алаг өвс-улалж-биелэг өвст-үетэн тухайлбал Крыловын хялгана (*Stipa Krylovii*), саман ерхөг (*Agropyron cristatum*), дэrvээн хазар өвс (*Cleistogenes squarrosa*), том цэцэгт дааган сүүл (*Koeleria macrantha*), сунагар биелэг өвс (*Poa attenuata*), агь (*Artemisia frigida*), ишгэн шарилж (*Artemisia dracunculus*), Адамсын шарилж (*Artemisia Adamsii*), ишгүй гичгэнэ (*Potentilla acaulis*), имт гичгэнэ (*Potentilla bifurca*), дагуур хатны цэцэг (*Symbaria dahurica*), хоёр ишт бэриш (*Vupleurum bicaule*) зэрэг олон төрөл зүйлийн баялаг ургамлан нөмрөгтэй байсан. Тус төслийн талбай нь нийтдээ хүний үйл ажиллагаанд өртсөн ба үндсэн ургамлын бүлгэмдэлгүй болсон байна. Үндсэн ургамлан бүлгэмдэл устсан, нийт талбай сайр, хайргаар хучигдсан хашааны зах хэсгээр ишгэн шарилж, лууль, хамхуул бага зэрэг талбайг хамарна

2.10. Амьтны аймаг

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн суурьшлын бүс нь бүхэлдээ барилга

байгууламж баригдаж, хүн техникийн хүчин зүйлийн нөлөөнд өртсөн тул амьтны аймгийн төрөл зүйл дайжсан. Суурин газарт үзэгдэх зарим төрлийн шувуу байдаг. Барилгын үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл байхгүй.

2.11. Тусгай хамгаалалттай газар нутаг

Төслийн талбай нь Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт хамаарагдахгүй. Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх Богдхан уулын ДЦГ-аас 1.3 км зайд хотжилтийн бүсэд байрлана.

2.12. Түүх соёлын өв

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Таван Богд Проперти” ХХК-ийн “880 айлын орон сууц болон үйлчилгээний төв” байгуулах 29977 кв талбайн хэмжээнд түүх соёлын биет дурсгал байхгүй. Цаашид барилгын суурийн талбай бэлтгэх, газар шорооны ажлыг хийх үед газрын хөрсөн доороос мэдэгдээгүй соёлын биет өв илэрсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т “Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ” гэж заасны дагуу анхааран ажиллавал зохино.

2.13. Нийгэм-эдийн засаг

Дүүргийн хүн амын тоо: Хан-Уул нь 2019 оны байдлаар нийт 185,251 хүн амтай. Үүнээс эрэгтэй 88,540 хүн буюу 47.79 хувь, эмэгтэй 86,711 хүн буюу 52.21 хувийг эзэлж байна. 2015-2019 онуудад тус дүүргийн хүн амын тоо тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна.

Хүн амын ажил эрхлэлт: Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2020 оны 3 дугаар сард 569 байгаань өнгөрсөн оны мөн үеийнхээс 32 хүнээр нэмэгдсэн байна. Нийт ажилгүйчүүдийн 51.5 хувь нь эмэгтэйчүүд байна. 3 дугаар сард орон тооны цомхотголоор 28, байгууллага татан буугдсанаас 14, өөр газраас шилжиж ирсэн 22, сургууль төгссөн 5, мэргэжлийн ажил олдохгүй 13, цалин багатайгаас 24, бусад шалтгаанаар 87 хүн ажилгүй болжээ. Тайлант сард 38 хүн ажилд орсноос нөхөрлөл компанид 35, бусад газарт 3 хүн ажилд орсон байна.

Эрүүл мэнд: Дүүргийн хэмжээнд 2020 оны эхний 3 сард 313 хүн халдварт өвчнөөр өвчилсөнг өмнөх оны мөн үеэс 272 хүнээр (46.5%), 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсэн хүний тоо 16.4 продицимилээр буурсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 35.8 хувийг салхин цэцэг, 20.8 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 16.3 хувийг тэмбүү, 4.8 хувийг гар хөл амны өвчин, 3.2 хувийг трихомониаз, 10.2 хувийг цусан суулга, 4.1 хувийг заг хүйтэн, 4.8 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна

Дүүргийн төсөв: Дүүргийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого) 2020 оны эхний 3 сард 25.3 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 2.0 тэрбум төгрөгөөр (7.3%) дутуу бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2019 оноос 21.4 хувь өссөн байна. Төсвийн нийт орлогын 35.9 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 2.1 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого), 62.0 хувийг улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна.

Хэрэглээний үнэ: Хэрэглээний үнийн индекс 2020 оны 3 дугаар сард өмнөх оны эцэстэй

“Таван Богд Проперти” ХХК-ийн “880 айлын орон сууц болон үйлчилгээний төв байгуулах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

харьцуулахад 3.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 8.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 3.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ

1.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 0.8 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 1.2 хувь, тээврийн үйлчилгээний бүлгийн үнэ 1.8 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний үнэ 0.1 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 2.9 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 0.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэр: Нийслэлийн аж үйлдвэрийн газрууд 2019 онд урьдчилсан гүйцэтгэлээр 9.8 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 11.8 их наяд төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх онтой харьцуулахад үйлдвэрлэлт 3.2 хувиар, борлуулалт 5.3 хувиар өссөн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг өмнөх онтой харьцуулахад цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэлт 15.2 хувиар, боловсруулах үйлдвэрлэлт 12.1 хувиар, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 5.2 хувиар тус тус өсөж, уул уурхайн олборлох үйлдвэрлэлт 2.8 хувиар буурсан байна

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Энэ хэсэгт байгаль орчны судалгааны явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаварыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зардал зэргийг оруулсан болно.

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт	Тайлбар
Агаар					
1.	Барилгын талбай бэлтгэх газар шорооны ажил болон машин техникийн хөдөлгөөний шилжилтээс тоосжилт үүсэх	Талбай бэлтгэх, газар шорооны ажлын үед үүсэх тоосжилтыг бууруулахдаа усалгааны аргыг ашиглах бол хөрсний шүүрлийн усыг дахин ашиглах	Орчны тоосжилт, шороон зам	Газар шорооны ажил хийгдээгүй	Газар шорооны ажил хийгдээгүй
2.		Мөн барилгын материал тээвэрлэлтийн үед үүсэх тоосжилтыг бууруулахдаа машины дугуй угаах аргыг ашиглах. Үүнд мөн шүүрлийн усыг ашиглаж болно		Хэрэгжүүлж ажилласан	Барилгын талбайг асфальтан хучилттай болгосон учраас усалгаа хийх шаардлагагүй болсон.
3.		Барилга үйлдвэрлэлийн дотоод замд хурдны хязгаар тогтоох		Барилга үйлдвэрлэлийн дотоод зам	Хэрэгжүүлж ажилласан
4.	Том оврын машин техникийн хөдөлгүүрээс ялгарах хорт хий нь орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.	Машин техникүүдийг үзлэг оношилгоонд хамруулах	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм	Хэрэгжүүлж ажилласан	Байгууллагын хэмжээнд нийтдээ Toyota prius 30 – 2 ш, Toyota land cruiser 200 – 1 ш, daewoo 8 ton – 1 ш, Kia, bongo 3 – 1 ш, hyundia, mighty – 1 ширхэг машинуудыг үйл ажиллагаанд ашиглаж байгаа бөгөөд товлосон хугацаанд татварыг төлж, үзлэг оношлогоонд хамруулан, тухай бүрт сервис үйлчилгээг хийж ажиллаж байна.
5.		Ажлын талбайд гадаад орчны агаарын чанарын шинжилгээ хийлгэх	Барилгын талбайн хэмжээнд	Хэрэгжүүлж ажилласан	Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан агаарын чанарын хэмжилтийг хийж гүйцэтгүүлсэн.
Хөрс					
6.	Талбайн зохионбайгуулалт	Барилгын материалын хураалтыг эмх цэгцтэй	Барилгын материал	Хэрэгжүүлж ажилласан	Төсөлд ашигласан барилгын материалуудыг эмх цэгцтэй хурааж, зориулалтын сав баглаа боодолтой нь хадгалсан

“Таван Богд Проперти” ХХК-ийн “880 айлын орон сууц болон үйлчилгээний төв байгуулах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

	муугаас Хөрс элэгдэл, эвдрэлд хүчтэй өртөх, хог хаягдал ил задгай хаягдаж орчинд тархах	байлгаж, хөрсний элэгдэл, эвдрэлийг бага байлгах үүднээс суурин дээр байрлуулах. Тухайлбал арматур төмөр, шугам хоолой г.м			
7.	Шатах тослох материал асгарч хөрс бохирдох	ШТМ-ыг хадгалах сав талбайдбайрлуулах бол хөрсөнд нэвчиж бохирдуулахаас сэргийлэн савыг бетонон сууринд дээр байрлуулах, суурийн захаар шингэн урсаж гарахаас сэргийлсэн өндөрлөгөөтэй байх, газардуулагч байрлуулах	Шатах тослох материал	Хэрэгжүүлж ажилласан	ШТМ-ыг хадгалах сав талбайдбайрлуулах шаардлага гараагүй
9.	Хог хаягдлаар хөрс бохирдох	Барилга угсралтын шатанд ажилчдын ахуйн болон барилгын хог хаягдал хуримтлуулах цэгийг битүүмжлэл сайтай байгуулж, богино хугацаанд зайлуулах	Хог хаягдал	Хэрэгжүүлж ажилласан	Хог хаягдлыг хуримтлуулах цэгийг контейнероор хийж, хог хаягдал тээвэрлэх, зайлуулах гэрээг “Есел транс” ХХК-тай байгуулан тухай бүрт хог хаягдлыг ачилт тээвэрлэлтийг хийлгэж байна.
10.	Хог хаягдлаас орчинд таагүй үнэр тархах, ялзарч муудах	Хог хаягдлын цэг болон ажилчдын бие засах газар, гал тогоо, хооллох хэсэг зэрэгт хортон шавьж, мэрэгч, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэх	Хог хаягдлын цэг, бие засах газар	Хэрэгжүүлж ажилласан	Ариутгал, халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан улирал тутамд хийлгэдэг.
11.	Борооны ус, нар салхины нөлөөгөөр шинж чанар нь өөрчлөгддөг, болзошгүй байдлаар асгарсан үед хөрс бохирдуулах, салхиар туугдан орчинд тархах магадлалтай	Савалгаатай барилгын материалын сав баглаа боодлын бүрэн бүтэн байдалд анхаарч, тусгайлан бэлтгэсэн чингэлэг, агуулах зэрэгт хадгалах	цемент, цавуу, тосолгооны материал, будаг г.м	Хэрэгжүүлж ажилласан	Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах агуулахад зориулалтын дагуу хадгалан ашиглах үедээ төслийн талбай руу бага бага хэмжээгээр зөөж ашигласан
Ус					

“Таван Богд Проперти” ХХК-ийн “880 айлын орон сууц болон үйлчилгээний төв байгуулах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

12.	Ус зайлуулах хоолой,суваг зэргийг зураг төслийн дагуу хийгээгүйн улмаас зам талбай усанд автах, барилгын суурийн хийцлэлд сөргөөр нөлөөлөх	Барилгын дээвэр болон гадаа зам талбайн борооны ус, хөрсний ус зайлуулах хоолойг зураг төслийн дагуу холболт хийж, суурилуулах	Борооны ус зайлуулах хоолой, шугам	Хэрэгжүүлж ажилласан	Төслийн хэмжээнд борооны ус зайлуулах хоолой болон хөрсний ус зайлуулах хоолойг хийж ашиглалтанд хяналт тавин ажиллаж байна.
13.	Газрын доорх усны нөөцөд ачаалал үзүүлэх	Орон сууцны хотхоны сан техникийн шугам сүлжээ, тоноглолын чанарт анхаарч, ус хэмнэгч төхөөрөмжүүд суурилуулах, Усыг агаартай хольж шүрших технологи бүхий шүршүүр Ус хэмнэгч суултуур Борооны ус зайлуулах Барилгын дээврийн болон хур тунадасны усыг зүлэг, мод услах болон зам талбайн цэвэрлэгээнд зориулан ашиглах системийг төлөвлөж болно	Газрын доорх усанд ачаалал үүсгэх	Хэрэгжүүлж ажилласан	Орон сууцанд ашиглаж буй холигч, шүршүүр зэргийг хийхдээ усны хэмжнэлттэйг технологи бүхий хэрэгслийг суурьлуулсан.
14.	Ундны ус нь стандартын шаардлага хангахгүй байх	Төвлөрсөн шугамын усанд хяналт шинжилгээ хийлгэх	Орон сууцны барилгын төвлөрсөн шугамын ус	Хэрэгжүүлж ажилласан	Төвлөрсөн шугамын усыг лабораторид шинжлүүлж усны унд ахуйд нийцэж буй талаар дүгнэлт гаргуулсан.

3.2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Тайгын ногоон хишиг ХХК-тай гэрээ байгуулж, 1-р ээлжийн ногоон байгууламжийг хийж гүйцэтгэсэн

3.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төсөл хэрэгжүүлэгч “Таван Богд Проперти” ХХК нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлжбуй Төслийн барилгын талбай бэлтгэх, гадна сүлжээ байгууламж, суваг байгуулах, газар шорооны ажил хийгдэх үед газрын хөрсөн доороос мэдэгдээгүй үлдсэн соёлын өв илэрсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т “Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан

“Таван Богд Проперти” ХХК-ийн “880 айлын орон сууц болон үйлчилгээний төв байгуулах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

байгууллагад нэн даруй мэдэгдэнэ”, мөн “БНБД 12-01-09 Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт”-ын 7.11-д “Хэрэв барилгын ажлын явцад археологийн болон түүх, соёлын олдвор газрын гүнээс илрэх тохиолодолд ажлыг даруй зогсоож энэ чиглэлийн холбогдох байгууллага, харьяа орон нутагт мэдэгдэх” гэжзаасны дагуу анхааран ажиллавал зохино.

3.4. Тэрбум модны хүрээнд хийгдэх ажлын биелэлт

Төслийн талбайн ашиглалттай дээвэр, гадна талбайд гацуур, нарс, тэхийн шээг, голт бор, монос, өрөл, тавилгана, гүйлс, нохойн хошуу зэрэг 1155 мод, бутыг төлөвлөгөөний дагуу тарьж суулгасан. 2-р ээлжийн барилгын ногоон байгууламжийн мод тарих ажил эхлэн хийгдэж байна.

3.5. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 4. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар
Тухайн жилийн ажил эхлүүлэхтэй холбогдсон ажлын хүрээнд					
1.	Ажлын байрны осол аваар, эрсдэл	Эрсдэл өндөр ажил буюу ухалт малталт, тоног төхөөрөмж ашиглах, өндөрт ажиллах, цахилгааны ажлуудад Хяналтын инженер, гүйцэтгэгч компаниудын инженер, ажилтнуудтай хамтарч эрсдэлийн үнэлгээнд хийх	Эрсдэл ихтэй хэсгүүд	Хэрэгжүүлж ажилласан	2023 онд Барилга угсралтын ажил гүйцэтгэхээр ирсэн гүйцэтгэгч байгууллагуудаас хийгдэх ажилбар тус бүрээр 40 эрдсэлийн үнэлгээг хийлгэн хянаж, сайжруулах саналыг өгч ажиллав.
2.	Баримт бичгийн бүрдүүлэлт хангалтгүй байх	Гүйцэтгэгч компаниудын ХАБЭА-н бичиг баримтын бүрдэлд дэмжлэг үзүүлэх, шалгах	ХАБЭА-н баримт бичгийн бүрдүүлэлт	Хэрэгжүүлж ажилласан	Гүйцэтгэгч байгууллагыг ажил гүйцэтгэх гэрээний хавсралтын дагуу бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтын дагуу авч, өдөр тутмын ажилд хяналт тавьж сайжруулах шаардлагатай асуудлыг тухай бүрт талбайн даалгавраар хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулж ажиллав.
3.	Барилгын хяналт, зохион байгуулалт муу байх	Төслийн талбайн нэвтрэлтэд хяналт тавих	Барилгын үйлдвэрлэлийн бүрдүүлэлт	Хэрэгжүүлж ажилласан	
Талбайн зохион байгуулалтын ажлын хүрээнд					
4.	Талбайн зохион байгуулалт алдагдах	Барилга үйлдвэрлэлийн талбай болон түр байр, хооллох хэсгийн тохижилтыг норм дүрмийн дагуу байгуулах	Ажилчдын амрах, хооллох хэсэг	Хэрэгжүүлж ажилласан	Төслийн талбай руу нэвтрэх ажилтан, зочдыг харуулын 1-р постоор нэвтрүүлж, цахим бүртгэлийн систем болон зочны зааварчилгааны дэвтэрт бүртгэн хяналт

“Таван Богд Проперти” ХХК-ийн “880 айлын орон сууц болон үйлчилгээний төв байгуулах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

					тавьж ажилдаг.
5.	Талбай дахь бараа материал хураалт зохион байгуулалтгүй байх, ажилчдад тавих хяналт сулрах	Төслийн талбай руу нэвтэрч буй ажилтан, техник хэрэгсэл, бараа материалуудад хяналт тавих, согтуурлын зэрэг шалгах	Барилгын үйлдвэрлэлийн талбай	Хэрэгжүүлж ажилласан	24 цагийн харуул хамгаалалт ажиллаж, цахим бүртгэлээр нэвтрүүлдэг.
6.	Ажлын байрны осол эрсдэлнэмэгдэх	Талбайн гэрэлтүүлэг, камерийн бүтэн байдал, хашааны бүрэнбүтэн байдал, орц гарц, хаалт хашилт, тэмдэг тэмдэглэгээндхяналт тавих, цаашид сайжруулах	Ажлын талбай	Хэрэгжүүлж ажилласан	Төслийн хэмжээнд нийт 431 хяналтын камер ажиллаж байгаа, 12/36 цагаар 4 оператор ээлжлэн ажиллаж оршин суугчид болон төслийн аюулгүй байдлыг хангуулан ажилладаг. Гадна гэрэлтүүлэг 40 тавьсан бөгөөд орой 18:00 цагаас өглөөний 7 цагийн хооронд ажилладаг.
Дотоод хяналт үзлэг шалгалтын хүрээнд					
7.	Ажлын байрны аюулгүй ажиллагааны бэлэн байдлын хяналт	ХАБЭА-н инженерүүд нь ажлын байрны үзлэг хийж илэрсэн зөрчлүүдийг тогтоосон хугацаанд нь арилгуулах	Ажлын байр	Хэрэгжүүлж ажилласан	ХАБЭА-н албанаас 2023 оны хугацаанд ХАБЭА-н I, II, III, IV шатны хяналтыг нийт 21 удаа хийж 1032 үл тохирол илрүүлэн талбайн даалгавраар хугацаатай үүрэг даалгавар өгч тохирол болгон ажиллаа. Мөн Таван богд группийн ХАБЭА-н хэлтсээс төлөвлөгөөт хяналт шалгалтаар 17 үл тохирол илрүүлснийг товлосон хугацаан залруулгын арга хэмжээ авч тохирол болгосон.
Галын аюулгүй байдлыг хангах чиглэлээр					
8.	Галын аюулын эсрэг бэлэн байдалхангалтгүй байх	Галын аюулгүй байдлыг хангуулах, галын сараа, галын хор шалгах, баталгаажуулах	Галын аюулгүй байдлын хэсэг	Хэрэгжүүлж ажилласан	Галын аюулгүй байдал хариуцсан 10 ажилтанг гүйцэтгэх захирлын тушаалаар томилон Таван богд группийн ХАБЭА-н хэлтсийн галын идэвхитний сургалтанд хамруулж чадавхижуулсан. Мөн сар бүр төслийн хэмжээнд байгаа галын хор, гал унтраах усан системийн үйл ажиллагаанд хяналт тавин, үл тохирол илэрсэн тохиолдолд хариу арга хэмжээ авч тохирол болгон ажиллаж байна.
9.		Ажилчдын галын аюулгүй байдлын мэдлэгийг дээшлүүлэх, онцгой байдлын үед ажиллахдадлага сургалтыг зохион байгуулах	Ажилчид	Хэрэгжүүлж ажилласан	Хан-Уул дүүргийн онцгой байдлын хэлтсээс онцгой байдлын үед ажиллах дадлага сургалтыг 7 сард авсан. Мөн байгууллагын ажилтнуудад галын хор ашиглах сургалтыг улирал бүр хийж, нунтаг галын хор ашиглан гал унтраах

“Таван Богд Проперти” ХХК-ийн “880 айлын орон сууц болон үйлчилгээний төв байгуулах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

					арга техникт сургаж байна.
10.		Талбайд галын гарцын тэмдэглэгээ, галын хорнуудын тэмдэглэгээ, аврах гарцын бүдүүвчийг байршуулах, цаашид тодотгол хийх	Барилгын талбай	Хэрэгжүүлж ажилласан	Хан-Уул дүүргийн онцгой байдлын хэлтсээс төслийн хэмжээнд ажиллан 1-р ээлжийн барилгуудын галын аюулгүй байдлыг шалгаж, галын дүгнэлтийг гаргасан. Мөн оффисын барилгын аврах гарцын схем зургийг батлав.
Эрүүл ахуйн хангах чиглэлээр					
11.		Компаний нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Бүх ажилчид	Хэрэгжүүлж ажилласан	2023 онд эрүүл мэндийн хугацаат үзлэгт дөрөвдүгээр эмнэлэгт 25 ажилтан, Таван богд нура оношлогооны төвд 32 ажилтан, нийт 57 ажилтан урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан.
12.	Ажилчдын мэргэжлээс шалтгаалах өвчлөл нэмэгдэх, өртөх	Бүх ажилчдыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамруулах	Бүх ажилчид	Хэрэгжүүлж ажилласан	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалыг Мандал даатгал ХХК-тай гэрээ байгуулж, нийт 75 ажилтныг нэгж ажилтны 50,000,000 төгрөгийн үнэлгээтэй 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 9-ний өдөр хүртэлх хугацаатай даатгуулсан.
13.	Болзошгүй осол эрсдэлийн эсрэг бэлэн байдал алдагдах	Анхны тусламж үзүүлэх зааварчилгааны самбар, эмийн сангийн иж бүрдэл байршуулж, цаашид шалгаж, тодотгол хийх	ХАБЭА	Хэрэгжүүлж ажилласан	Анхны тусламж үзүүлэх зааварчилгааны самбар, эмийн сангийн иж бүрдэл байршуулж ажилласан
Цахилгааны аюулгүй ажиллагаа					
14.	Талбайн тэмдэглэгээ, хаягжуулалт муу байснаас осол аваар гарах	Төслийн талбай дээрх түр тэжээлийн самбаруудын тэмдэг тэмдэглэгээ, дохио санамж, хаягжуулалт, цахилгааны холболтын схем хийж, цаашид тодотгол хийн сайжруулж байх	Барилгын талбайн тэмдэгжүүлэлт	Хэрэгжүүлж ажилласан	Төслийн талбай дээрх түр тэжээлийн самбаруудын тэмдэг тэмдэглэгээ, дохио санамж, хаягжуулалт хийж ажилласан.
15.	Зуны аянга цахилгаантай үед металл хийц бүхий арматур болон бусад төмөр тоног төхөөрөмжөөр дамжин ажиллагсад аянга цахилгааны осолд өртөж болзошгүй	Цахилгааны ерөнхий самбарын газардуулгыг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулалт хийлгэх, газардуулгын акт гаргуулах	Газардуулга	Хэрэгжүүлж ажилласан	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулсан.
Ажилчдыг чадваржуулах, ХАБЭА-н сургалт зохион байгуулах ажлын хүрээнд /байгууллага дотооддоо/					

“Таван Богд Проперти” ХХК-ийн “880 айлын орон сууц болон үйлчилгээний төв байгуулах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

16.		Нийт ажилтны ХАБЭАн сургалт	Бүх ажилчид	Хэрэгжүүлж ажилласан	Байгууллагын хэмжээнд нийт ажилтны сургалтыг дээрх агуулгын хүрээнд зохион байгуулж 67 ажилтан хамрагдсан. Ажилтнуудын ХАБЭА-н мэдлэг сэргэж, сургалтын агуулгын хүрээнд мэдлэг бататгах тест өгч шалгалтын дундаж 88%-аас дээш үнэлэгдсэн.
17.	Ажилчид ажлын байрны осол аваргарт өртөх, эрүүл мэндэд хохирол учрах	Шинээр ажилд орж буй ажилтны сургалт	Шинэ ажилтан	Хэрэгжүүлж ажилласан	Таван Богд Групп уг хуулийн шаардлагад нийцүүлэн 7 хоног бүрийн 3-н өдөр Урьдчилсан зааварчилгыг тогтмол зохион байгуулдаг ба илүү олон ажилтнуудыг цаг алдалгүй хамруулах үүднээс Даваа гараг бүрийн сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулдаг. 2023 оны хугацаанд манай байгууллагаас
18.		Барилга үйлдвэрлэлийн талбайн аюулыг илрүүлэх, мэдээлэх, арилгах аян зохион байгуулах	Барилга угсралтын талбай	Хэрэгжүүлж ажилласан	ХАБЭА-н мэдлэг сургалтын агуулгын хүрээнд аян зохион байгуулсан
Мэргэжлийн байгууллагаас авах сургалт					
19.	Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон ажилчдын санамсаргүй байдлаас осол, аваар гаргах	Өндрийн сургалт	Өндөрт ажиллах ажилчид	Хэрэгжүүлж ажилласан	2023 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Аюулгүй ишлэл ХАБЭА-н сургалтын төвөөс “Өндөрт ажил гүйцэтгэх аюулгүй ажиллагааны аргачлал” сургалтыг авч нийт 10 ажилтан хамрагдаж мэргэжлийн үнэмлэх авсан.
20.		Онцгой байдлын үед ажиллах сургалт	Бүх ажилчид	Хэрэгжүүлж ажилласан	
Нэг бүрийн болон тусгай, нийтийн хамгаалах хэрэгсэлийг бүрдүүлэх чиглэлээр					
21.	Ажилчид нэг бүрийн хамгаалах хэрэгслийг бүрэн хэрэглээгүйгээс эрүүл мэнд хохирох	Бүх ажилчдыг нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хангах, бүртгэл хөтлөх	Бүх ажилчдын НБХХ	Хэрэгжүүлж ажилласан	Үндсэн болон туслан гүйцэтгэгч компаний ажилчдыг өдөр тутам ажлын хувцас болон бусад хамгаалах хэрэгсэлтэй ажилд шалгаж гаргадаг.
Байгалийн гаралтай аюул, эрсдэл					
22.	Зуны бороо хур их үед борооны ус бууж барилгын талбайн хөрсийг угаах, барилгын зоорийн давхарт хийгдэх ажилд саад учруулах, усаардүүрэх	Талбайн борооны ус зайлуулах суваг, хоолойг төлөвлөлт, зураг төслийн дагуу байгуулах	Барилгын талбай	Хэрэгжүүлж ажилласан	Зураг төслийн дагуу борооны ус зайлуулах системийг хийж гүйцэтгэсэн

3.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хог хаягдлын тухай хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах харилцааг зохицуулахад оршино.

Хүснэгт 5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт	Тайлбар
1	Ахуйн	Эрх бүхий байгууллагатай Хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөр төлөх	Хог хаягдал	Хэрэгжүүлж ажилласан	Есел транс компанитай хог хаягдлын гэрээ байгуулан 2023 онд нийт 606 удаа хог хаягдлыг тээвэрлүүлж 151,500,000 төгрөгийн зардал гаргасан.
		Ахуйн хог хаягдлыг боломжит хувилбараар ангилан ялгаж, бүртгэл хөтлөх	Хог хаягдал	Хэрэгжүүлж ажилласан	Хог хаягдал ангилан ялгаж хаях хогийн сав байршуулсан.
		Барилгын үйл ажиллагааны үед графикт болон өдөр тутамхийгдэх хог цэвэрлэгээний ажилд хяналт тавих	Хог хаягдал	Хэрэгжүүлж ажилласан	ХАБЭА-н албанаас Гэрлүг виста төслийн хэмжээнд 7 хоног бүр их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж хэрэгжилтийг хангуулж ажилласан.
		Ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх	Хог хаягдлын цэг, ажилчдын бие засах газар, гал тогооны хэсэг	Хэрэгжүүлж ажилласан	Ариутгал, халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан улирал тутамд хийлгэдэг.
		Барилга ашиглалтанд орсны дараах үеийн айл өрх, үйлчилгээний газраас гарах хог хаягдлыг ангилан ялгах боломжтой байдлаар хогийн цэгийг төлөвлөж, байгуулах	Хотхоны хог хаягдал	Хэрэгжүүлж ажилласан	Хог хаягдал ангилан ялгаж хаях хогийн сав байршуулсан.
2.	Барилгын	Барилгын хог хаягдлыг ангилан ялгаж	Барилгын хаягдал	Хэрэгжүүлж ажилласан	Ангилан ялгаж ачуулсан
		Ангилан ялгасан хог хаягдлаас дахин ашиглах боломжтой хаягдлыг түүхий эдийн цэгт нийлүүлэх	Дахин ашиглах барилгын хаягдал	Хэрэгжүүлж ажилласан	Ангилан ялгаж ачуулсан
		Ашиглах боломжгүй хог хаягдлыг тээвэрлэгчид нийлүүлж, үйлчилгээний хөлсийг төлөх	Барилгын хаягдал	Хэрэгжүүлж ажилласан	Гэрээний дагуу хог хаягдлын төлбөрийг төлсөн

3.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт


Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тухайн төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн байгаа орчны бүрэлдэхүүн хэсэг (агаар, хөрс, усан орчин)-т сөрөг нөлөөлөл, өөрчлөлтийг үзүүлж байгаа эсэхэд хяналт тавих, бохирдлыг хянах боломж бүрдэнэ.

Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Зардал, мян.төг	Хэрэгжилт	Тайлбар
Барилга угсралтын үе шатны гадаад орчны агаар							
1.	Хүхэрлэг хий (SO ₂)	Барилга үйлдвэрлэлийн талбайд нийт 2-3 цэг сонгоно	6-р сард	Жилд 1 удаа	300.0	Хэрэгжүүлж ажилласан	Мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэсэн.
2.	Азотын давхар исэл (NO ₂)						
3.	Нарийн болон том ширхэглэгт тоосонцор (TSP)						
4.	Дуу чимээ						
Хөрс							
1.	Хүнд металлын үзүүлэлт	Барилгын талбайд 2- оос доошгүй цэг сонгоно /машины түр зогсоол, түлш хадгалах савны орчим г.м/	6-р сард	Жилд 1 удаа	120.0	Хэрэгжүүлж ажилласан	Мэргэжлийн байгууллагаар дээж авахуулан лабораторид шинжлүүлсэн
2.	Хөрсний физик химийн шинж чанар	Барилгын талбайд 2- оос доошгүй цэг сонгоно	6-р сард	Жилд 1 удаа	60.0	Хэрэгжүүлж ажилласан	Мэргэжлийн байгууллагаар дээж авахуулан лабораторид шинжлүүлсэн
Ус							
1.	Физик-химийн шинж чанар	Төвлөрсөн шугамын ус	Барилга ашиглалтанд орохын өмнө	1	70.0	Хэрэгжүүлж ажилласан	Мэргэжлийн байгууллагаар дээж авахуулан лабораторид шинжлүүлсэн

4. Хэрэгжилтийн зургууд.

1. Барилгын талбайн зам талбайд асфальтан зам тавьсан байдал



2. Машин техникүүдийг үзлэг оношилгоонд хамруулах

<p>Тээврийн хэрэгсэл</p> <p>Улсын дугаар 2011УБР Загвар Toyota Prius Үйлдвэрлэсэн он 2012</p>	<p>Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> Узлэгт орсон огноо 2023/09/16 Узлэгт дахин орох огноо 2024/09/16 Тэнцсэн эсэх Тэнцсэн 	<p>Тээврийн хэрэгсэл</p> <p>Улсын дугаар 0324УНР Загвар Toyota Prius Үйлдвэрлэсэн он 2012</p>	<p>Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> Узлэгт орсон огноо 2023/09/18 Узлэгт дахин орох огноо 2024/09/18 Тэнцсэн эсэх Тэнцсэн
<p>Үндсэн цэс</p> <ul style="list-style-type: none"> Гэрчилгээний мэдээлэл Оношилгооны мэдээлэл Давтгалын мэдээлэл Татвар, хураамж Торгууль Ачилт, журамлалт Хот хоорондын зам ашигласны хураамж Зогсоолын төлбөр Төлбөрийн түүх 		<p>Үндсэн цэс</p> <ul style="list-style-type: none"> Гэрчилгээний мэдээлэл Оношилгооны мэдээлэл Давтгалын мэдээлэл Татвар, хураамж Торгууль Ачилт, журамлалт Хот хоорондын зам ашигласны хураамж Зогсоолын төлбөр Төлбөрийн түүх 	
<p>Тээврийн хэрэгсэл</p> <p>Улсын дугаар 0218УБЕ Загвар Toyota Land Cruiser Үйлдвэрлэсэн он 2017</p>	<p>Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> Узлэгт орсон огноо 2023/09/24 Узлэгт дахин орох огноо 2024/09/24 Тэнцсэн эсэх Тэнцсэн 	<p>Тээврийн хэрэгсэл</p> <p>Улсын дугаар 2519УАС Загвар Hyundai Mighty Үйлдвэрлэсэн он 2006</p>	<p>Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> Узлэгт орсон огноо 2023/09/16 Узлэгт дахин орох огноо 2024/09/16 Тэнцсэн эсэх Тэнцсэн
<p>Үндсэн цэс</p> <ul style="list-style-type: none"> Гэрчилгээний мэдээлэл Оношилгооны мэдээлэл Давтгалын мэдээлэл Татвар, хураамж Торгууль Ачилт, журамлалт Хот хоорондын зам ашигласны хураамж Зогсоолын төлбөр Төлбөрийн түүх 		<p>Үндсэн цэс</p> <ul style="list-style-type: none"> Гэрчилгээний мэдээлэл Оношилгооны мэдээлэл Давтгалын мэдээлэл Татвар, хураамж Торгууль Ачилт, журамлалт Хот хоорондын зам ашигласны хураамж Зогсоолын төлбөр Төлбөрийн түүх 	<p>Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл</p> <p>Узлэгт орсон огноо 2023/09/16</p> <p>Узлэгт дахин орох огноо 2024/09/16</p> <p>Тэнцсэн эсэх Тэнцсэн</p>

“Таван Богд Проперти” ХХК-ийн “880 айлын орон сууц болон үйлчилгээний төв байгуулах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Тээврийн хэрэгсэл	Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл	Тээврийн хэрэгсэл	Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл
Улсын дугаар 9841VBC Загвар KIA Niro 3 Үйлдвэрлэсэн он 2016	Узлагт орсон огноо 2023/06/27 Узлагт дахин орох огноо 2024/06/27 Тэнцсэн эсэх <input checked="" type="checkbox"/> Тэнцсэн	Улсын дугаар 5027AO Загвар Daewoo 8TON Үйлдвэрлэсэн он 2010	Узлагт орсон огноо 2023/09/24 Узлагт дахин орох огноо 2024/09/24 Тэнцсэн эсэх <input checked="" type="checkbox"/> Тэнцсэн
Үндсэн цэс <ul style="list-style-type: none">Гэрчилгээний мэдээлэлОношилгооны мэдээлэлДавтгалын мэдээлэлТатвар, хураамжТоргуульАжилт, журамлалтХот хоорондын зам ашигласны хураамжЗогсоолын төлбөрТөлбөрийн түүх		Үндсэн цэс <ul style="list-style-type: none">Гэрчилгээний мэдээлэлОношилгооны мэдээлэлДавтгалын мэдээлэлТатвар, хураамжТоргуульАжилт, журамлалтХот хоорондын зам ашигласны хураамжЗогсоолын төлбөрТөлбөрийн түүх	

3. Ажлын талбайд гадаад орчны агаарын чанарын шинжилгээ хийлгэх




4. Барилгын материалын хураалтыг эмх цэгцтэй байлгаж, хөрсний элэгдэл, эвдрэлийг бага байлгах үүднээс суурин дээр байрлуулах. Тухайлбал арматур төмөр, шугам хоолой г.м



5. Барилга угсралтын шатанд ажилчдын ахуйн болон барилгын хог хаягдал хуримтлуулах цэгийг битүүмжлэл сайтай байгуулж, богино хугацаанд зайлуулах

“Таван Богд Проперти” ХХК-ийн “880 айлын орон сууц болон үйлчилгээний төв байгуулах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан




6. Хог хаягдлын цэг болон ажилчдын бие засах газар, гал тогоо, хооллох хэсэг зэрэгт хортон шавьж, мэрэгч, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэх



- 7. Савалгаатай барилгын материалын сав баглаа боодлын бүрэн бүтэн байдалд анхаарч, тусгайлан бэлтгэсэн чингэлэг, агуулах зэрэгт хадгалах**



- 8. Барилгын дээвэр болон гадаа зам талбайн борооны ус, хөрсний ус зайлуулах хоолойг зураг төслийн дагуу холболт хийж, суурилуулах**




- 9. Төслийн талбайд гацуур, нарс, тэхийн шээг, голт бор, монос, өрөл, тавилгана, гүйлс, нохойн хошуу зэрэг нийт 1155 мод тарина.**






10. Эрсдэл өндөр ажил буюу ухалт малталт, тоног төхөөрөмж ашиглах, өндөрт ажиллах, цахилгааны ажлуудад Хяналтын инженер, гүйцэтгэгч компаниудын инженер, ажилтнуудтай хамтарч эрсдэлийн үнэлгээнд хийх, Төслийн талбайн нэвтрэлтэд хяналт тавих




11. Төслийн талбай руу нэвтэрч буй ажилтан, техник хэрэгсэл, бараа материалуудад хяналт тавих, согтуурлын зэрэг шалгах



“Таван Богд Проперти” ХХК-ийн “880 айлын орон сууц болон үйлчилгээний төв байгуулах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан




12. Талбайн гэрэлтүүлэг, камерийн бүтэн байдал, хашааны бүрэн бүтэн байдал, орц гарц, хаалт хашилт, тэмдэг тэмдэглэгээнд хяналт тавих, цаашид сайжруулах



13. ХАБЭА-н инженерүүд нь ажлын байрны үзлэг хийж илэрсэн зөрчлүүдийг тогтоосон хугацаанд нь арилгуулах




14. Галын аюулгүй байдлыг хангуулах, галын сараа, галын хор шалгах, баталгаажуулах



15. Ажилчдын галын аюулгүй байдлын мэдлэгийг дээшлүүлэх, онцгой байдлын үед ажиллах дадлага сургалтыг зохион байгуулах



16. Талбайд галын гарцын тэмдэглэгээ, галын хорнуудын тэмдэглэгээ, аврах гарцын бүдүүвчийг байршуулах, цаашид тодотгол хийх



17. Компаний нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах



18. Бүх ажилчдыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамруулах

АЖИЛЧДЫН ОСОЛ, НӨХӨН ОЛГОВРЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН: АЖИЛЧДЫН ОСОЛ, НӨХӨН ОЛГОВРЫН ДААТГАЛ
2. ДААТГАГЧ: "МАНДАЛ ДААТГАЛ" ХК
3. ДААТГУУЛАГЧ: "ТАВАН БОГД ПРОПЕРТИ" ХХК
4. ДААТГАЛЫН ЗҮЙЛ: Даатгуулагчтай хөлсөөр ажиллах болон хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа ажилтнуудын амь нас, эрүүл мэндэд учирсан хохирол
5. ДААТГАЛЫН ХУГАЦАА: Эхлэх: 2023 оны 8-р сарын 10 ны өдрийн 00:00 цагаас
Дуусах: 2024 оны 8-р сарын 9-ны өдрийн 23:59 цаг хүртэл
6. ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ: Нэг ажилтны үнэлгээ: 50,000,000 төгрөг
Нийт үнэлгээ: 3,200,000,000 төгрөг
(Нэг ажилтны үнэлгээг 36 сарын цалингийн нийлбэр дүнгээр тогтооно)

19. Анхны тусламж үзүүлэх зааварчилгааны самбар, эмийн сангийн иж бүрдэл байршуулж, цаашид шалгаж, тодотгол хийх



20. Төслийн талбай дээрх түр тэжээлийн самбаруудын тэмдэг тэмдэглэгээ, дохио санамж, хаягжуулалт, цахилгааны холболтын схем хийж, цаашид тодотгол хийн сайжруулж байх



21. Нийт ажилтны ХАБЭАн сургалт

ЗОРИЛГО: А370 журмын шаардлага, хөтөлбөрийн дагуу нийт ажилтанд ХАБЭА-н тухай суурь болон хууль эрхзүйн мэдлэг олгох, өмнө олгогдсон мэдлэгийг бататгах, сэргээх

ХУГАЦАА: 2023 оны 05 сарын 29, 15:00-17:00 цагт

ХАМРАХ ХҮРЭЭ: “Таван богд проперти” ХХК-ийн ажилтнууд

СУРГАЛТЫН ХЭЛБЭР: Танхим


НИЙТ ЦАГ: 2 цаг

Сэдэв	Агуулга	Сургагч багш	Цаг
Нээлт	Сургалтын ирцийн бүртгэл		16:00-16:05
1. ХАБЭА-н тухай хууль, тогтоомж	<ul style="list-style-type: none"> • Хууль • Тогтоол • Стандарт 		16:05-16:25
2. Хөдөлмөрийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн нөхцөл • Хөдөлмөрийн нөхцлийн сөрөг хүчин зүйлс 		16:25-16:45
Завсарлага			16:45-16:55
3. Эргономик хүчин зүйл	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндэд нөлөөлөх нь • Дасгал хөдөлгөөн хийх 		16:55-17:25
4. Галын аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> • Гал гарах хүчин зүйлс • Галын аюулаас урьдчилан сэргийлэх нь 		17:25-17:45
5. Шалгалт	<ul style="list-style-type: none"> • Мэдлэг бататгах тест бөглөх 		17:45-17:55

22. Шинээр ажилд орж буй ажилтны сургалт


Таван Богд Групп уг хуулийн шаардлагад нийцүүлэн 7 хоног бүрийн 3-н өдөр Урьдчилсан зааварчилгыг тогтмол зохион байгуулдаг ба илүү олон ажилтнуудыг цаг алдалгүй хамруулах үүднээс Даваа гараг бүрийн сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулдаг.

23. Өндрийн сургалт



24. Бүх ажилчдыг нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хангах, бүртгэл хөтлөх

25. Талбайн борооны ус зайлуулах суваг, хоолойг төлөвлөлт, зураг төслийн дагуу байгуулах



26. Эрх бүхий байгууллагатай Хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөр төлөх



27. Барилгын үйл ажиллагааны үед графикт болон өдөр тутам хийгдэх хог цэвэрлэгээний ажилд хяналт тавих



28. Ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх



29. Барилга ашиглалтанд орсны дараах үеийн айл өрх, үйлчилгээний газраас гарах хог хаягдлыг ангилан ялгах боломжтой байдлаар хогийн цэгийг төлөвлөж, байгуулах



ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ	32
2. Хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрчилгээ.....	33
3. Кадастрын зураг.....	36
4. Ерөнхий үнэлгээний дүгнэлт.....	37
5. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний батлагдсан нүүр.....	40
6. Байгаль орчны менежмент төлөвлөгөө 5 жилээр батлагдсан нүүр.....	41
7. Байгаль орчны менежмент төлөвлөгөө 2022 он биелэлтийг дүгнэх хуудас.....	42
8. Усны шинжилгээний дүгнэлт.....	44
9. Хөрсний шинжилгээний дүгнэлт.....	45
10. Газрын төлбөр тооцоо нийлсэн акт.....	46
11. Хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээ.....	47
12. Есел транс ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ.....	50
13. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт.....	52
14. Дулааны эрчим хүч, хэрэгцээний халуун хүйтэн усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээ.....	54
15. Хэрэгцээний усны төлбөр төлсөн баримт.....	63
16. 2-р ээлжийн барилгуудын газардуулга эсэргүүцэл хэмжилтийн үр дүн.....	65